

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2016.08.15

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг төлөөлж итгэмжлэлээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Тэргүүн дэд захиралын багийн захирал Ж.Төмөрпүрэв хурал даргалагчаар, хувьцааны 8,9 хувийг эзэмшигч “Fire Bird” сангийн зүгээс брокерийн байгууллагаар дамжуулан бичгээр 5 санал өгсөн бөгөөд Би Ди Сек ХХК-ийн төлөөлөгчөөр Б.Билгүүн нар ирж оролцсон болно.

Түүнчлэн “Шивээ Овоо” ХК-ийн зүгээс Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар, Дэд захирал Х.Халиун, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Пүрэвбаатар, Д.Батсүх Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга О.Чинхүсэл, Тооллогын комиссын дарга С.Одбаяр, гишүүн Х.Дашжаргал С.Боргил нар мөн оролцлоо.

Хурлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын удирдамж, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөгч Ж.Төмөрпүрэв даргалан явуулахаар боллоо.

О.Чинхүсэл: Хуралд ирсэн төлөөлөгч болон хувьцаа эзэмшигч нарыг танилцуулж хурлын даргыг хурлыг нээхийг хүслээ.

Хурлын дарга: Та бүхэн сайн байцгаана уу. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг нээснийг мэдэгдье. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуул гэв.

Тооллогын комиссын дарга С.Одбаяр: “Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг хувьцаа эзэмшдэг нийт 1619 хувьцаа эзэмшигчдээс 1,136,949ш хувьцаа эзэмшигч нь брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох 2 санал ирүүлсэн байна. 12,086,145ш хувьцаа эзэмшдэг нийт 2 хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 2 хүн итгэмжлэлээр хуралд оролцож нийт 13,223,094 ш хувьцаатай хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 98,54 хувьтай байна. “Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц бүрдсэн тул хурлыг нээхийг зөвшөөрөх нь зүйтэй байна.

Хурлын дарга: Хурлын хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулаад баталья гэв.

1. Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэхэд шаардлагатай 20.9 сая еврогийн санхүүгийн эх үүсвэрийг Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражового (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлийн гэрээ байгуулж шийдвэрлэхийг Гүйцэтгэх захирал зөвшөөрч тус зээлийн барьцаа хөрөнгийг компанийн үндсэн хөрөнгөөс бүрдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал даалгах эрх олгох.

Sign



№	ХУРЛЫН ДЭГ	ХУГАЦАА, ЦАГ, МИНУТ
1	Хурлын ирц мэдээлэх / Зохион байгуулах комисс/	5 минут
2	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
3	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх	Асуудал тус бүр дээр 30 хүртэл минут
4	Хуралд оролцогсдын асуулт, хариулт, санал дүгнэлт авах	Хүн тус бүрээс 5 минут
5	Завсарлага	15 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг танилцуулах	15 минут
8	Хурлын ажиллагааг хаах	5 минут

Хурлын дэгийг баталах уу. Хуралд ороцож буй нийт оролцогчдийн саналаар хурлын дэгийг дээрх байдлаар батлав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-1

Хурлын дарга: Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэхэд шаардлагатай 20.9 сая еврогийн санхүүгийн эх үүсвэрийг Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражового (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлийн гэрээ байгуулж шийдвэрлэхийг Гүйцэтгэх захирал зөвшөөрч тус зээлийн барьцаа хөрөнгийг компанийн үндсэн хөрөнгөөс бүрдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал даалгах эрх олгохтой холбогдох танилцуулгыг дэд захирал Х.Халиун танилцуулна.

Х.Халиун: Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэх системийн талаар танилцуулая. Танилцуулгыг дараах байдлаар танилцуулна.

- Тасралтгүй ажиллагаат ЭКО систем нэвтрүүлэх үйл явц.
- Системийн давуу тал.
- Системийн танилцуулга.
- Системийн эдийн засгийн үр ашиг.

2015 оны ТУЗ-ын 2015 оны 01 сарын 20-ны өдрийн хурлаар компанийн алдагдлыг бууруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор "Тасралтгүй үйл ажиллагаат ЭКО технологи" нэвтрүүлэх төслийг танилцуулан дэмжүүлж төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулах, ТЭЗҮ-ийг боловсруулах, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэхийг гүйцэтгэх захиралд үүрэг болгосон.

Үйлдвэрлэгч БНПУ-ын Фамур компанитай ЭКО системийг худалдах, худалдан авах гэрээг байгуулсан.

Sign



ШУТИС-ийн дэргэдэх Уул уурхайн хүрээлэнтэй хамтарч тасралтгүй ажиллагаат ЭКО систем нэвтрүүлэх ТЭЗҮ-г боловсруулан 2015 оны 07 сарын 02-ны өдөр Уул уурхайн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж ТЭЗҮ-г хүлээн авах шийдвэрийг гаргуулан, Ашигт малтмалын газрын даргын г/90 тоот тушаалаар албажуулсан.

2016 оны 04 сарын 18-ны өдөр Шивээ-Овоогийн уурхайд уулын үйлдвэрлэлийн дэвшилтэд тасралтгүй ажиллагаат ЭКО технологийг нэвтрүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж төсөлд шаардлагатай санхүүжилтийг БНПУ-ын Хөгжлийн банкнаас Монгол улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлдүүлэх хэлбэрээр шийдвэрлэх талаар Засгийн газрын 219 тоот тогтоол гарсан

Монгол улсын Хөгжлийн банкны тухай хууль, дотоод журамд заасны дагуу зээл авахад бүрдүүлэх шаардлагатай материалуудын жагсаалтыг 2016 оны 06 сарын 02 өдрийн 6/634 тоот албан бичгээр уурхайд ирүүлсэн. Үүний дагуу Зээл хүсэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээс бусад материалуудыг бүрдүүлж хүргүүлээд байна.

Төсөл хэрэгжиснээр уурхайн нэг м.куб тээвэртэй хөрс хуулалтын өнөөгийн өртөг 2857 төгрөгийг 914 төгрөг болгон 3,1 дахин бууруулж 4,4 сая м.куб хөрс хуулан овоолго үүсгэнэ гэж тооцоход ашиглалтын зардлын хэмнэлт жилд 8,5 тэрбум төгрөг буюу хэмнэсэн зардлаараа 6 жилд төслийн хөрөнгө оруулалтыг бүрэн нөхнө. Үүнээс гадна ЭКО систем нь 1 сая.тн нүүрс нэмж олборлон борлуулах боломжийг олгох бөгөөд энэ нь нүүрсний өнөөгийн үнээр 23 тэрбум төгрөгийн орлогыг нэмж бүрдүүлнэ. Уурхайд оруулах нэмэлт орлого, нийт зардлын хэмнэлтээр 2 жилд төслийн хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөөд ашиглалтын үлдсэн 28 жилд жил бүр 12 тэрбум төгрөгөөр үйлдвэрлэлийн зардлыг бууруулна.

Ашиглалтын зардал:

Олон утгуурт экскаватор, конвейер, овоолго үүсгэгчийн системийн ашиглалтын зардлыг уламжлалт автотээврийн системтэй харьцуулахад: өрөмдлөг тэсэлгээ, дизель түлш, дугуй, зам арчилгаа, овоолго хэлбэржүүлэлтийн зардлуудыг 100 хувь, тос тослох материал, сэлбэг хэрэгсэл, цалин, НДШ, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлуудыг 27-150 хувиар бууруулна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал:


Тасралтгүй ажиллагаат систем нь бүрэн автомат буюу хөрс хуулах, тээвэрлэх үйлдвэрлэлийн процесс дахь хүний оролцоо хамгийн бага, техник тоног төхөөрөмж тус бүрийн үйл ажиллагааны хяналтын системтэй, өнөөдрийн байдлаар хөрс хуулалтын бусад технологиудтай харьцуулахад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хамгийн илүү хангасан систем болно.

Тасралтгүй ажиллагаа, бүтээмж:

Тэсэлгээний материал, дизель түлшний ханган нийлүүлэлтээс хамааралгүй, эвдрэл гэмтэл, сэлбэг зарцуулалт болон хүнтэй холбоотой ашиглалтын буруутай ажиллагаанаас шалтгаалсан сул зогсолт бага, тасралтгүй ажиллагаатай, бүтээл өндөр, найдвартай систем юм.

Санхүүжилтийн нөхцөл:

Польш улсын хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих төсөл бөгөөд эрсдэл болон зээлийн хүү бага, эргэн төлөлтийн хуваарь уян хатан буюу хөрөнгө оруулалтыг уурхай өөрийн хөрөнгөөр эргэн төлөх бүрэн боломжтой. Төслийн санхүүжилт 2 үе шаттай. Нэгдүгээрт: Урьдчилгаа тоног төхөөрөмжийн үнийн дүнгийн 15 хувь буюу 3,14 сая евро-г 2 жилийн хугацаатай баталгаат бус хөрөнгө татан төвлөрүүлэхгүй аккредитив нээх замаар

Sign 

шийдвэрлэх, Хоёрдугаарт: Зээл 20,97 сая /хүү, даатгал, банкны зардал, үндсэн зээл/ евро-г 2+5 жилийн хугацаанд төлөх хөнгөлөлттэй нөхцөлтэй.

Технологийн зарим хүндрэлийг шийдвэрлэх:

ЭШ-25/90 алхагч экскаваторын шидэлтийг бууруулж, орлын өргөнийг багасгаснаар фронтын уртаар хөрс хуулалтыг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр шилжилт хөдөлгөөн бага хийж бүтээл нэмэгдэх, дотоод овоолгын ачаалал буурч, чулуулгийн тогтворжилтын өнцгийг 28 градусаас бага байлгах боломж бүрдэнэ. Үүний үр дүнд ажлын бус талын гурвалжингийн нүүрсийг хаягдалгүй олборлох нөхцөл бүрдэх бөгөөд үүнтэй холбоотойгоор инженерийн ажил 60 хүртэл хувиар буурна.

Байгаль орчин экологи: Агаарт хүлэмжийн хий ялгаруулдаггүй, тоосжилт бага.


Төслийн зорилго:

“Шивээ-Овоо” уурхайн хөрс хуулалт, тээвэрлэлт, овоолго үүсгэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэгж бүтээгдэхүүний өртгийг бууруулж зардал хэмнэх, ингэснээр 2018 оноос компанийг ашигтай ажиллуулах.

Хүчин чадал:

Тасралтгүй ажиллагаат системийн онолын бүтээл нь 2000м.куб/цаг. Төсөлд системийг онолын бүтээлийн 47%-иар ашиглахаар төлөвлөсөн бөгөөд энэхүү төлөвлөлтөөр систем нь жилд 4,4 сая метр.куб буюу 8,5 сая тонн хөрс хуулж, тээвэрлэн овоолго үүсгэнэ.

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Экскаватор, конвейер, овоолго үүсгэгчийн систем	Уламжлалт экскаватор, автотээврийн хослол	Харьцуулалт	
					Дүнгийн зөрүү	Тасралтгүй ажиллагаат системийн давуу тал
1	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Мян. м3	4 406,20	4 406,20	-	Ижил
2	Хөрөнгө оруулалтын хэмжээ	Сая.төг	54,109.7	101 122,70	47 013	86 хувиар хэмнэлттэй
3	Санхүүжилтийн жилийн хүү	Хувь	2,4	10	7.6	Жилийн хүүнд зарцуулагдах зардал 4,1 дахин бага
4	Жилийн хүүгийн зардал	мян.төг	964 369,3	4 086 755,10	3 122 385,8	
5	Жилийн үндсэн төлөлт	мян.төг	4 304 499,10	10 359 342,90	6054 843,70	Жилийн үндсэн төлөлт 2,4 дахин бага

Sign 

6	Хөрөнгө оруулалт нөхөх хугацаа	Жил	2 - 5,9	Нөхөх боломжгүй		Тээвэртэй хөрс хуулалтын системтэй харьцуулсан зардлын хэмнэлтээр 5,9 жил, уурхайд оруулах нэмэлт орлого, нийт зардлын хэмнэлтээр 2 жилд хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөөд ашиглалтын үлдсэн 28 жилд жил бүр 12 тэрбум төгрөгөөр үйлдвэрлэлийн зардлыг бууруулна.
7	Нэг жилийн ашиглалтын зардал	мян.төг	4 029 146,80	12 589 978,10	8 560 831,30	Ашиглалтын зардлыг 3 дахин бууруулна.
8	1 метр куб хөрс хуулж, тээвэрлэх үеийн зардал	төг/куб	914,43	2 857,33	1 942,91	1 метр куб хөрс хуулах, тээвэрлэх зардлыг 3 дахин бууруулна.
9	Төслийн үр дүн					Хэмнэлттэй, үр ашигтай

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу асуулт хариултаа эхлүүлэе.

Б.Билгүүн: Энэхүү төслийн санхүүжилтийн төлбөрийг шинээр гаргах нэмэлт хувьцаа борлуулсаны орлогоор бүрдүүлэхүү?

Х.Халиун: хувьцаа борлуулсаны орлогоос бол бүрдүүлэхгүй байдлаар мөнгөн урсгалын тооцоогоо гаргасан байгаа.

Хурлын дарга: Энэ төсөл хэрэгжсэнээр ажлын байр багасна гэж ойлгож байна. Тэгэхээр нийгмийн асуудал энэ тэр нь нэлээн хүчтэй тавигдаж байх. Шинээр дахиж орон тоо бий болгохуу?

О.Отгонбаатар: Энэ төсөл дээр нийт 53 хүн ажиллах боломжтой. Уламжлалт хөрс хуулалтын технолгийг хэрэглэхгүй учраас тэнд ажиллаж байгаа хүмүүсээ шилжүүлнэ. Тэгэхээр нийт орон тооноос хасагдаж нэмэгдэх зүйл гарахгүй байх.

Б.Пүрэвбаатар: "Эрдэнэс Монгол" ХХК-ийн байр суурь ямар байгаа юм бэ? Ямар удирдамж ирүүлсэн юм бол.

Хурлын дарга: "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захиралын тушаалаар удирдамж ирүүлсэнийг та бүхэнд уншиж сонсоё.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөгч нь "Шивээ Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Компанийн тухай хууль, Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм, "Шивээ Овоо" ХК-ийн дүрэм, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү удирдамжийг баримтлана. Үүнд:

Sign 

Энэ хүрээнд Засгийн газрын 2016 оны 04 сарын 18-ны өдрийн 219 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс уулын үйлдвэрлэлийн дэвшилтэд тасралгүй ажиллагаат технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай 20.9 сая еврогийн санхүүгийн эх үүсвэрийг Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражового (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлийн гэрээ байгуулж шийдвэрлэхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрч, тус зээлийн барьцаа хөрөнгийг компанийн үндсэн хөрөнгөөс бүрдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгах санал өгөх гэж ирүүлсэн байна.

Одоо өөр асуултгүй бол саналаа хураая. Тооллогын комисс ажиллаж саналаа хураан уу.

Тооллогын комиссын дарга С.Одбаяр: "Шивээ Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс 13,223,094 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлсэн асуудалд доорх байдлаар саналаа өгсөн байна. Хүчингүй саналын хуудас 0

1. Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэхэд шаардлагатай 20.9 сая еврогийн санхүүгийн эх үүсвэрийг Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражового (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлийн гэрээ байгуулж шийдвэрлэхийг Гүйцэтгэх захирал зөвшөөрч тус зээлийн барьцаа хөрөнгийг компанийн үндсэн хөрөнгөөс бүрдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал даалгах эрх олгох асуудлыг

зөвшөөрсөн	12,077,191	санал буюу	91,34 хувь
татгалзсан	1,145,903	санал буюу	8,66 хувь
түдгэлзсэн	0	санал буюу	0 хувь

Хурлын дарга: Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулая.

Компанийн тухай хуулийн 62.1.10 дугаар заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.6 дугаар заалт, Засгийн газрын 2016 оны 04 сарын 18-ны өдрийн 219 дугаар тогтоол, "Шивээ Овоо" ХК-ийн дүрмийн 10.10.5 дугаар заалтыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:


1. Роторт экскаватор, хөрс тээврийн конвейер, овоолго үүсгэгчийн тасралтгүй ажиллагаат технологи нэвтрүүлэхэд шаардлагатай 20.9 сая еврогийн санхүүгийн эх үүсвэрийг Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражового (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан зээлийн гэрээ байгуулж авахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т зөвшөөрсүгэй.
2. Тус зээлийн барьцаанд шаардлагатай хөрөнгийг компанийн үндсэн хөрөнгөөс бүрдүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т даалгасугай.

Sign



Тогтоолын төслийн талаар тусгайлсан саналтай хувьцаа эзэмшигч байсангүй.
Хувьцаа эзэмшигчдийн хурал 15:30 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Ж. ТӨМӨРПҮРЭВ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



О.ЧИНХҮСЭЛ

Sign

